GOVERNMENT OF MONGOLIA MINISTRY OF INDUSTRY

# REQUEST FOR EXPRESSION OF INTEREST

**Selection of the consortium incorporated with a Mongolian national company that invests and implements the construction project of an oil refinery in Mongolia.**

The Ministry of Industry now invites eligible consortiums[1] incorporated with national company (hereinafter referred to as "Consortium") to express their interest in investing and implementing the construction project of an oil refinery with a capacity of up to 2.3 million tons per year, in Bor-Undur soum of Khentii province, in order to implement Mongolian Government Resolution #75 of 2016.

All interested consortiums shall meet the following general requirements:

- Shall be a consortium with participation of Mongolian national company[2];
- At least one member of the consortium shall have experience in constructing and commissioning a similar oil refinery within last 10 years;
- The consortium shall be an oil refining technology license holder or be able to obtain such technology license.

The consortium must submit an official Letter of interest /"LOI"/ written in either Mongolian or English expressing their interest in the bid along with the following documents on April 07, 2016 before 3:00 pm (Ulaanbaatar time) to the address below.

1. Introduction of the consortium;
2. The consortium shall appoint only one authorized representative and the power of authorized representative shall be validated by the power of attorney issued by each member of the consortium in accordance with relevant laws;

[1] "Consortium incorporated with national company (-ies)" means the incorporation of foreign or domestic legal persons that includes Mongolian national company (-ies). In case of winning the bid, the consortium shall establish and register the legal entity within 1/one/ month of signing the "Project investment and implementation agreement" in accordance with the Company Law of Mongolia and the Mongolian national company shall hold no less than 10 percent of the total share capital of such entity.

[2]"Mongolian national company" means an entity whose 76% or more share issues owned by a citizen or legal person of Mongolia or a Mongolian registered legal entity.

3. Introduction of each member of the consortium which includes official name, address, detailed description of business operation and experience;
4. A certificate of incorporation or company registration documents of each member of the consortium;
5. Audited financial statements for the last 3 years and detailed descriptions of business capability and current financial position of each member of the consortium;
6. Receipt of a non-refundable bidding fee of 3 (three) million MNT. *Payable to: The Ministry of Industry, Account num; 900038001, State Treasury Bank*

Within 3 working days of receiving the expressions of interest, the Ministry of Industry shall examine the documents submitted to ensure compliance with the general requirements and notify the consortiums whether they qualify for the bid in writing or by e-mail. The bidding document shall be handed over to the authorized representative of the consortium.

The consortiums shall be fully responsible for their business operation, assets, financial position and the accuracy of the information provided in the bidding process.

For detailed information regarding the bid, please contact the address below during working hours between 09:00-17:00.

**The Ministry of Industry**


**Attn: Ts.Oyunbold, *Officer at Oil, coal and chemical industry division of Heavy Industry Policy Department***

**Address: Room No. 102, Government Building-2,**
**United Nation's Street-5/1, Ulaanbaatar-15160, Mongolia**
**Tel: +976-51-261734, +976-51-264179, Fax: +976-51-263333**
**E-mail :** oyunbold.ts@mi.gov.mn, **Website: www.mi.gov.mn**


----oOo---

[1] "Consortium incorporated with national company (-ies)" means the incorporation of foreign or domestic legal persons that includes Mongolian national company (-ies). In case of winning the bid, the consortium shall establish and register the legal entity within 1/one/ month of signing the "Project investment and implementation agreement" in accordance with the Company Law of Mongolia and the Mongolian national company shall hold no less than 10 percent of the total share capital of such entity.

[2]"Mongolian national company" means an entity whose 76% or more share issues owned by a citizen or legal person of Mongolia or a Mongolian registered legal entity.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ ИРҮҮЛЭХ ЗАР МЭДЭЭ

**“Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-д хөрөнгө оруулж, төслийг хэрэгжүүлэх үндэсний компани (ууд)-ийн оролцоотой консорциумыг сонгох уралдаант шалгаруулалт.**

Аж үйлдвэрийн яам нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 75 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд жилд 2.3 сая тонн хүртэл хүчин чадалтай газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-д хөрөнгө оруулж, төслийг хэрэгжүүлэх үндэсний компани(ууд)-ийн оролцоотой консорциумыг* /цаашид “Хүсэлт гаргагч” гэх/ сонгох уралдаант шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдийг хүсэлтээ ирүүлэхийг урьж байна.

Уралдаант шалгаруулалтад оролцох хүсэлт гаргагч нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

- Монгол Улсын Үндэсний компани(ууд)** -ийн оролцоотой консорциум байх.
- Консорциумын аль нэг гишүүн сүүлийн 10 жилд ижил төстэй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж, ажиллуулсан туршлагатай байх.
- Консорциум нь газрын тос боловсруулах үйлдвэрт хэрэглэгдэх технологи эзэмшдэг, эсвэл технологийн лиценз авах боломжтой байх.

Уралдаант шалгаруулалтад оролцох хүсэлт гаргагч нь хүсэлтээ илэрхийлсэн албан ёсны захидлыг Монгол эсвэл Англи хэл дээр бэлтгэж, дараах материалын хамт 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 15:00 цагт (Улаанбаатарын цагаар) багтаан биеэр, бичгээр зар мэдээнд бичигдсэн хаягаар ирүүлнэ. Үүнд:

1. Хүсэлт гаргагчийн танилцуулга;
2. Консорциум нь зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг холбогдох журмын дагуу түүнд консорциумын гишүүн бүрийн бичгээр өгсөн итгэмжлэлтэй байх;
3. Консорциумын гишүүн бүрийн албан ёсны нэр, хаяг болон үйл ажиллагаа, ажлын туршлагын тухай дэлгэрэнгүй танилцуулга;
4. Консорциумын гишүүн бүр /компани/-ийг үүсгэн байгуулж, бүртгүүлсэн тухай баримт бичгүүд;
5. Консорциумын гишүүн бүрийн сүүлийн 3 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, бизнесийн чадавх, санхүүгийн байдлын тухай танилцуулга;
6. Буцаан төлөгдөхгүй нөхцөлтэй уралдаант шалгаруулалтын хураамж болох 3.0 /гурав/ сая төгрөгийг төлсөн баримт. /“Төрийн сан” банк дахь Аж үйлдвэрийн яамны 900038001 дугаартай данс/;

Аж үйлдвэрийн яам хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 /гурав/ хоногт багтаан ерөнхий болон бусад шаардлагыг хангаж буй эсэхийг хянаж, уралдаант шалгаруулалтад цаашид оролцох эсэх тухай мэдэгдэлийг бичгээр хүсэлт гаргагч этгээдэд шуудан болон цахим шуудангийн аль боломжтойгоор нь хүргүүлнэ. Уралдаант шалгаруулалтын бичиг баримтыг хүсэлт гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид гардуулан өгнө.

Хүсэлт гаргагч өөрийн эрхэлж буй үйл ажиллагаа болон эрх зүйн байдал, хөрөнгө, санхүүгийн байдал, уралдаант шалгаруулалтад ирүүлсэн бусад мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцна.

Энэхүү уралдаант шалгаруулалттай холбоотой нэмэлт мэдээллийг доорх хаягаар ажлын 09:00-17:00 цагийн хооронд авч болно.

**АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

**Хэнд: Аж үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын мэргэжилтэн Ц.Оюунболд**
**Хаяг: Нэгдсэн үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр, 102 тоот**
**Улаанбаатар, Монгол Улс**
**Утас: 97651-261734**
**976 51-264179**
**Факс: 976 51-263333**
**Е-Мэйл:** oyunbold.ts@mi.gov.mn
**Цахим хуудас: www.mi.gov.mn**

* “Үндэсний компани (ууд)-ийн оролцоотой консорциум” гэж Монгол Улсын Үндэсний компани(ууд) бүрэлдэхүүнд нь оролцсон, гадаад, дотоодын хуулийн этгээдүүдийн нэгдлийг хэлнэ. Уралдаант шалгаруулалтад шалгарсан нөхцөлд ”Хөрөнгө оруулах, төслийг хэрэгжүүлэх” гэрээ байгуулсан өдрөөс хойш 1 /нэг/ сарын дотор багтаж Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн дагуу төслийг хэрэгжүүлэх компанийг байгуулж бүртгүүлэх, байгуулсан компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас доошгүй хувийг консорциумын гишүүн Монгол Улсын Үндэсний компани(ууд) эзэмшихээр тусгасан байна .

** “Монгол Улсын Үндэсний компани” гэж Монгол Улсын иргэн, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд нийт гаргасан хувьцааных нь 76 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийг хэлнэ.